



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/258

Булган сум

**Тамирчдад шаардлагатай хэрэглэгдэхүүн материалын зардалд хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өсвөрийн шигшээ багийг бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд тамирчдад шаардлагатай хэрэглэгдэхүүн материалыг нэмэгдүүлэх зорилгоор сагсны бөмбөг 10 ширхэг, волейболын бөмбөг 10 ширхгийг тус тус худалдан авахад шаардагдах 3,600,000 (гурван сая зургаан зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Шаардагдах зардлыг хавсралтаар баталж, “Биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөр төлөвлөгөө”-ний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны  
04 дүгээр сарын 19-ны өдрийн А/209 дугаар  
захирамжийн хавсралт



Тамирчдад шаардлагатай хэрэглэгдэхүүн материалын төсөв

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	1	2	3	4
1	Сагсан бөмбөг	10ш	180,000	1,800,000
2	Волейболын бөмбөг	10ш	180,000	1,800,000
<b>Нийт үнэ</b>				<b>3,600,000</b>